

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч, инфляци өснө хэмээн АХБ үзэж байна

Хонгконг, БНХАУ (2008 оны 4 дүгээр сарын 2) – Дотооддоо хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа мөнгөний хумих бодлого болон гадаад зах зээлийн эрэлт хэрэгцээний бууралт зэргээс хамааран БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч, 2008-2009 онуудад 10 орчим хувьтай байна гэж Азийн хөгжлийн банк (АХБ)-наас саяхан гаргасан томоохон тайланд дурьджээ.

АХБ-наас Азийн орнуудын эдийн засгийн талаар урьдчилсан таамаглал дэвшүүлэн “*Азийн хөгжлийн төлөв*”(АХТ) тайланг жил бүр гаргадаг бөгөөд өнөөдөр гаргасан *2008 оны* тайланд БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарч, сүүлийн 13 жилийн хамгийн өндөр өсөлт болох 2007 оны 11.4 хувьтай харьцуулахад 2008 онд 10 хувь, 2009 онд 9.8 хувь байхаар тооцоолсон байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хэрэглээний хувь хэмжээ нь 2008 онд өсөх хандлагатай байгаа бөгөөд хөрөнгө оруулалт ч мөн өсөлтийн гол хүчин зүйл байхаар байна.

Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт нь эдийн засаг дахь инфляцийн хөөрөгдлийг дэвэргэнэ хэмээн дээрхи товхимол (АХТ)-д анхааруулжээ. Хэрэглээний үнийн инфляци 2007 онд 4.8 хувь байсан бол 2008 онд дунджаар 5.5 хувь, 2009 онд 5 орчим хувьтай байх төлөвтэй байна.

“Мөнгөний бодлогын огцом бөгөөд хатуу арга хэмжээ, дэлхийн эдийн засгийн таатай бус төлөв байдал, зээлийн хатуу бодлого нь өсөлтийг боломжит доод хэмжээнд байлгана” хэмээн Манилад төвтэй АХБ-ны ахлах эдийн засагч Ифзал Али ярьж байна.

Худалдааны баланс ашигтай байгаа болон хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж байгаа нь бэлэн мөнгөний илүүдлийг бий болгох тул төрийн эрх баригчдын зүгээс юаны америк доллартай харьцах ханшийг хурдтай өсгөхийг зөвшөөрөх магадлалтай байна.

2007 оны 26 хувьтай харьцуулахад экспортын өсөлт нь 2008 онд 19 хувь, 2009 онд 18 хувь хүртэл буурах төлөвтэй байгаа бөгөөд энэ нь цаашид дэлхийн зах зээлийн эрэлт хэрэгцээ буурч, экспортын хөнгөлөлт багасч байгаатай холбоотой байна. Харин импортын хэмжээ нь юаны ханшны өсөлт, импортын тарифын бууралт болон импортыг дэмжих бусад бодлого хэрэгжүүлж байгаатай уялдан 2008-2009 онуудад өсөх хандлагатай байна.

Хэдийгээр худалдааны балансын ашиг нь 2008-2009 онуудад буурах хандлагатай байгаа боловч Олимпийн тоглолтоос олох орлого нь 2008 оны үйлчилгээний балансын алдагдлыг багасгана. Тус улсын өсөн нэмэгдэж буй гадаад валютын нөөцийн орлого болон гадаадаас орж ирж буй хөрөнгө оруулалтын өсөлт нь орлогын хэмжээг нэмэгдүүлнэ. Төлбөрийн урсгал дансны ашгийн ДНБ-нд эзлэх хувь нь 2007 онд 11 хувь байсан бол буурч 2008 онд 9.9 хувь, 2009 онд 8.6 хувийг тус тус эзлэхээр төлөвтэй байна.

Цаашид эдийн засгийн өсөлтийг өндөр түвшинд хадгалж, хөрөнгө оруулалт ба экспортоос хэт хамааралтай байдлаас зайлсхийхийн тулд эдийн засгийн үндсэн гурван тэнцвэргүй байдлыг шийдвэрлэхэд анхаарахыг тус тайланд зөвлөж байна.

“БНХАУ нь дотоодын хэрэглээгээ нэмэгдүүлэх, эрчим хүч, байгаль орчны асуудлыг шийдвэрлэх болон хот, хөдөөгийн өсөн нэмэгдэж байгаа орлогын ялгааг багасгах шаардлагатай” хэмээн АХБ зөвлөж байна.

Энэ тайланд засгийн газрын зүгээс өв тэгш нийгэм байгуулах талаар олон шинэ арга хэмжээг авч эхэлсэнийг мөн дурьдсан байна. Гэхдээ, энэхүү бодлого нь зарим бэрхшээлтэй тулгарч байна. Тухайлбал, хадгаламжийн ялангуяа байгууллагын хадгаламжийн өндөр хүү; орон нутгийн

АХБ-ны хэвлэлийн мэдээ 2008.4.02
Хуудас 2

удирдлагын зүгээс эдийн засгийн өсөлтөд түлхүү анхаарах явдал; эрчим хүчний хямд үнэ, байгал орчны бохирдлыг багасгах талаар дорвитой арга хэмжээ авахгүй байгаа болон гэр бүлийн бүртгэлийн тогтолцооны журам зэрэг болно.

АХБ нь нийгмийн эмзэг давхрагын хүмүүст ээлтэй эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжил, сайн засаглалаар дамжуулан Ази, Номхон далайн бүс нутагт ядуурлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон талт санхүүгийн байгууллага юм. АХБ 1966 онд байгуулагдсан бөгөөд 67 гишүүн оронтой, тэдгээрийн 48 нь тус бүс нутагт оршдог улс орнууд юм. 2007 оны байдлаар тус банкнаас нийтдээ 10,1 тэрбум ам долларын зээл, 673 сая ам долларын буцалтгүй тусламж, 243 сая долларын техник туслалцааны төслийн санхүүжилтийг гишүүн орнууддаа олгожээ.

Мүгүүйеэ даааааа дааааааааа бүүааоуе аиё:

Omana Nair
T: +63 2 632 5178
M: +63 918 914 7003
E-mail: onair@adb.org

Sabyasachi Mitra
T: +63 2 632 4139
M: +63 918 939 9069
E-mail: sabymitra@adb.org

АОА-ийг үгүүйеэ аиёеэ дааааа:

ADB Online Media Center: media.adb.org
ADB web site: www.adb.org
Монгол хувийг: www.adb.org/mnrm
вэбсайтаас тус тус авна уу.